

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/6/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг, Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг:

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг:

Аудитор: Г.Энхтөр

Утас: 96441690 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3-р байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	25

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.18 № 1-6/331

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ ИЛЧ ОНӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.АЗБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

444190339

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Т.Азбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 28-наас 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК нь Үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг чанартай дулаанаар хангах, хэрэглэгчдийг үйлдвэрлэлийн болон унд ахуйн стандартад тохирсон цэвэр усаар тасралтгүй хангаж, экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт нийцсэн усыг байгальд нийлүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн үүсгэн байгуулах баримт бичигт Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл

- Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж

Туслах үйл ажиллагааны чиглэл

- Хүн амын үйлдвэрлэлийн хэрэгцээний ус хуримтлуулан ариутгаж түгээх
- Зочид буудал

- Дэлгүүр
- Тоног төхөөрөмж угсралтын болон барилга угсралт, магистраль инженерийн шугам сүлжээ угсрах ажиллагаа

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Компаний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Усны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчилж батлаагүй байна.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Ординат ХХК-ийн Веницца” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогын 1.0 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь өөрийн орлогоороо зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээс материаллаг байдлын түвшинг тооцсонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны Нийт орлого 7,791,078.0 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 77,910.78 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцох нь оновчтой гэж аудитор үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 11 чиглэлээр аудитын 34 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 22 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 12 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Орон сууцны ноогдуулалтын “Ospro” програмын үлдэгдэл санхүүгийн тайлан бэлтгэж буй програмын үлдэгдэлтэй 4,584.0 мянган төгрөгийн зөрүүтэй байсныг залруулсан болно

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	20	26,897.30	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	6,281.90	
3	Албан шаардлага өгсөн	1	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		22	33,179.20	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1 Орлогын данстай холбоотой асуудал

2018 оны 12 дугаар сарын НӨАТ-ын тайланд 3,653,373,381.62 төгрөгийн борлуулалтыг тайлагнаагүй, ямар нэг орлогогүй тайланг цахимаар илгээсэн байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага өгөх

(ДГА-2019/6/СТА-ОНӨААН)

2.8.2.2 Балансын данстай холбоотой асуудал

Тооцоо нийлсэн актаар өглөг гараагүй боловч урьдчилж төлсөн дансанд төсөвт байгууллагуудаас төлөгдсөн гэх 6,281,911.8 төгрөгийн үндэслэлгүй өглөг байна. Тухайлбал Биеийн тамир спортын газарт 1,679,171.0 төгрөг, ЭМНДХэлтэст 3,066,756.8 төгрөг, Сайншанд хот тохижилтын газарт 1,046,005.0 төгрөг, Зүүнбаян ХТГ-т 489,979.0 төгрөг тус тус байна.

Энэ нь бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Дараагийн аудитаар орон сууцны ноогдуулалтын "Ospro" програмын бүртгэлийг санхүүгийн "Виница" програмын бүртгэлтэй тулгаж байгаа байдлыг давтан шалгах нь зүйтэй.
2. ТУЗ-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд өөрчлөлт орсон эсэх, гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тодорхой заасан эсэхийг нягтлах.
3. НБББББ-г шинэчилэн боловсруулж баталсан эсэх, салбар болон төв компанийн бүртгэлийг бодлогын дагуу бүртгэж байгаа эсэхийг анхаарах.
4. Мөнгөн урьдчилгаа /дараа тайлан/ олгох, тайлагнах, хяналт тавих, бүртгэл хөтлөх журам баталж мөрдсөн эсэх

Аудитын явцад анхаарал татахуйц дараах чухал асуудлууд байна. Үүнд:

1. ТУЗ-ийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тодорхой заагаагүй байна.
2. Тендерийн ажил гүйцэтгэхтэй холбогдуулан их хэмжээний худалдан авалтыг зээлээр болон бэлнээр БНХАУ-ын Эрээн хотоос шууд хийдэг байна.
3. БНХАУ-ын Эрээн хотоос худалдан авсан сэлбэг хэрэгсэл, бараа материалын баримт нь мөнгө шилжүүлсэн буюу төлбөр хүлээн авсан газрын баримт мөн болох нь тодорхойгүй байна.
4. Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг данс их хэмжээний үлдэгдэлтэй байна. Иймд энэ дансаар ямар ажил гүйлгээ бүртгэхийг НБББББ-т тодорхой зааж өгөхөөр байна.
5. Тус компани 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харьяа Татварын хэлтэст 398,044,120.65 төгрөгийн, Нийгмийн даатгалын хэлтэст 90,639,102.09 төгрөгийн тус тус их хэмжээний өртэй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2018 онд үндсэн болон туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого 7,791,078.0 мянган төгрөг, хүүгийн орлого 3,307.8 мянган төгрөг, алданги торгуулийн орлого 16,010.3 мянган төгрөг буюу нийт 7,810,396.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Үйл ажиллагааны зардлыг авч үзвэл борлуулсан бүтээгдэхүүний өртөг 7,168,992.4 мянган төгрөг, борлуулалтын маркетингийн зардалд 140,727.3 мянган төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 507,784.5 мянган төгрөг, бусад зардалд 69,864.4 мянган төгрөгийн зардал гарч, үндсэн бус үйл ажиллагааны алдагдал 178,208.5 төгрөг буюу тайлант хугацааны нийт алдагдал 225,181.0 мянган төгрөг байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хаягаар орж ажил гүйлгээг үзэхэд хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан

Энэ нь Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тус компани Айраг, Их хэт, Өргөн гэсэн 3 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд салбар болон төв компаний хоорондын тооцооны дансыг эргэлтийн хөрөнгө хэсэгт бусад эргэлийн хөрөнгө дансанд сөрөг утгаар илэрхийлж тайлагнасан, Өргөн салбар 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр байгуулагдсан гэх боловч салбарын санхүүгийн байдлын тайлан 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хуримтлагдсан ашгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь салбар болон төв компаний бүртгэл, хоорондын тооцоог хэрхэн бүртгэх талаар бодлогын баримт бичигт тусгаж эцэслэн батлаагүйтэй холбоотой байна.
2. Өмчийн өөрчлөлтийн тайланд эздийн өмчийн бусад хэсэг данс 12,535,035,088.33 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд энэ дансны бүртгэлийг тодорхой болгож компаний дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд зохих өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна
3. Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээрх үлдэгдэл тооцоо гаргасан нярвын тайлангийн үлдэгдэлтэй тохирохгүй байна. Тухайлбал нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэл 5-р сард бензин 19,478.44 /12л/ төгрөг, 6-р сард бензин 35,412.81 /22л/ төгрөг, дизель түлш 20,800.0 /11л/ төгрөг, 7-р сард бензин 78,216.08 /47л/ төгрөг, дизель түлш 4,788,290.56 /2350л/ төгрөг, 9-р сард дизель түлш 71,335.52 /35л/ төгрөг, 10-р сард бензин 68,123.83 /39л/ төгрөг, дизель түлш 159,142.9 /75л/ төгрөг, 11-р сард бензин 44,470.11 /24л/ төгрөг, 12-р сард бензин 35,548.62 /20л/ төгрөг, дизель түлш 476,036.36 /212л/ төгрөгөөр тус тус нярвын тайлангаас илүү байна

4. Тухайн компаний Өргөн салбарт нярав байхгүй нягтлан бодогч эд хөрөнгөө хариуцан тайлан гаргадаг байна.
5. Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлын хөлсийг олгож ХХОАТ-ын тооцоо хийсэн боловч НДШ-ийн тооцоо хийгээгүй байна. Тухайлбал 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдөр П.Эрдэнэбатад 3,000,000.0 төгрөг, 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр В.Болорцэцэгт 600,000.0 төгрөг тус тус олгосон байна. Мөн Айраг салбарын ажилчдад орон сууцны халаалтын хөлсний хөнгөлөлтийг үзүүлж байгаа боловч хөнгөлөлтөөс НДШ-ийн тооцоо хийгээгүй байна.
6. 2018 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/31 тоот тушаалаар үл хөдлөх хөрөнгө /3 өрөө байр/ 17,000,000.0 төгрөгөөр худалдан авсан боловч эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.
7. Компаний захирлын гаргасан тушаалын үндэслэл гаргасан шийдвэрт хамаарахгүй үндэслэл муутай тушаал гаргаж хөрөнгө зарцуулсан байна. Тухайлбал 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр А/116 тоот тушаалаар нэр бүхий 8 хүнд 9,000,000.0 төгрөгийн урамшуулал олгосон байна. Мөн гаргаж буй тушаалын утга найруулгын хувьд анхаарах зүйл байна. Тухайлбал 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Б/220 тоот тушаалын 2 дугаар заалтаар Т.Энхтуяаг борлуулалтын орлогоор цалинжуулж бусад нэмэгдлийг олгохоор заасан боловч цалинг "Орлогоор цалинждаг ажилчдын цалин тооцож олгох журам"-н дагуу бодож олгодог байна.
8. 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 2017-2019 онд мөрдөхөөр хамтын гэрээ байгуулан 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр бүртгүүлсэн бөгөөд тус гэрээ өнөөдрийг хүртэл мөрдөгдсөөр байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөхөөр байна. Өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 " хамтын гэрээг нэг жил түүнээс дээш хэлэлцээрийг хоёр жилийн хугацаагаар тус тус байгуулна" 15 дугаар зүйлийн 15.5 "бүртгүүлээгүй буюу хууль тогтоомжид нийцээгүй эсхүл ажилтны эрхийн байдлыг хууль тогтоомжид зааснаас дордуулсан хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг хүчин төгөлдөр бус гэж үзэх бөгөөд түүнийг биелүүлэхгүй" гэсэн заалтууд байна.
9. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдэх хуудсыг батлагдсан маягт зааврын дагуу хөтөлдөггүй байна.
10. Тус компаний Айраг салбар бэлнээр мөнгө шаардлагатай болсон үед 1-р гарын үсгийг Ш.Шинэбилэг, 2-р гарын үсгийг М.Отгонтуяа нар зуран Санхүү-3 гэсэн тамга дарж нярав Б.Энхчимэгийн хувийн дансанд шилжүүлэн авч зарцуулдаг байна. Гэвч тухайн данснаас хэзээ хэдэн төгрөг авсан баримт байхгүй байна. Тухайлбал 2018 оны 12 дугаар сарын 17-нд 1,995,800 төгрөг бэлнээр авсан баримт байхгүй байна.
11. 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/99 тоот тушаалаар баталсан байгууллагын дотоод журмын 12.3.5-д "Ажилтанд ар гэрийн гачигдал, сувилуулах, суралцах зэрэг бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар түр чөлөө хүссэн тохиолдолд цалинтай чөлөө олгож болно" гэж заасан байна. Энэ нь чөлөө олгох нөхцөл ойлгомжгүй мөн ямар цалин хөлс олгох нь тодорхойгүй байна.

12. Дансдын ерөнхий журнал Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 100 тоот тушаалаар баталсан маягтын дагуу гардаггүй байна.
13. Автомашин түрээслэн ажил гүйцэтгэж байгаа боловч гэрээнд гүйцэтгэх ажил үүргийн тоо хэмжээ, ажиллах норм, хугацааг тодорхой тусгаагүй, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэдэггүй байна. Тухайлбал Айраг салбар 2018 оны 12 дугаар сарын 14-нд XMGL маркын 47-79 дугаартай машин түрээслэн 1,980,000.0 төгрөг төлсөн байна.
14. Байгууллагуудаас нэхэмжилсэн дулаан, цэвэр, бохир ус зарцуулалтын тооцооны нэхэмжлэл, борлуулалтын тайлан хоорондоо зөрүүтэй байна. Тухайлбал Дорноговь аймгийн Шүүхийн тамгын газарт бичсэн 1-11 сарын нэхэмжлэл борлуулалтын тайлантай 2965010 төгрөгийн зөрүүтэй, 12 дугаар сард айл өрхөөс авах 718020 төгрөгийн тооцоог Шүүхийн тамгын газрын үлдэгдлээс хаасан, УССТөвд бичсэн нэхэмжлэл 3575609 төгрөгөөр илүү, Зүүнбаян Хүүхдийн цэцэрлэгийн илүү төлсөн 454098 төгрөгийг орон сууцны авлагын дансанд хааж бичсэн байна.
15. Дараа тайлангаар мөнгө гаргахдаа юунд зориулж, хаанаас юу худалдан авах тухай мөнгө хүссэн өргөдөлд тодорхой тусгадаггүй шаардлагатай хөрөнгийг тооцож өгдөггүй бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан илүү үлдэгдэлтэй гардаг байна. Тухайлбал 2018 оны 6 дугаар сарын 14-нд 310,424.0 төгрөг, 2018 оны 9 дүгээр сарын 25-нд 11,467,495.0 төгрөг шаардлагатай мөнгөнөөс илүү олгосон байна. Мөн мөнгөн урьдчилгааны тайлан /дараа тайлан/-г олгосон тухай бүр тайлагнадаггүй, хэд хэдэн урьдчилж авсан бэлэн мөнгөний тайланг нийлүүлэн тайлагнадаг байна. Тухайлбал 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гаалийн татварт зориулан Ц.Адьяасүрэнгийн авсан 20,000,000.0 төгрөгийг 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн тайлангаар хаасан байна
16. Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй тоо хэмжээгээр тайлагнасан байна. Няравын шатахууны тайлан НББ-н үлдэгдэлтэй зөрүүтэй байна.
17. Тус компани үндсэн үйл ажиллагаанаас гадна туслах үйл ажиллагааны чиглэлээр компаний ид ачааллын бус цагаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр зарласан тендерт оролцон ажил гүйцэтгэсэн байна. Гэхдээ туслах үйл ажиллагааны чиглэлээр олсон орлого зардал, ашиг алдагдлын тооцоог гүйцэтгэсэн ажил тус бүрээр санхүүгийн тайланд тодруулаагүй байна. 2018 онд 1,975,035,163.0 төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна.
18. Компани өөрийн онцлогт тохируулан анхан шатны маягтууд хөтөлж байгаа боловч эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй зарим анхан шатны маягт ойлгомжгүй, тодорхой бус нягтлан бодох бүртгэлээр дамжуулан хүлээн авах мэдээллийн хэрэгцээг хангахгүй байна. Тухайлбал "томилолт олгох жагсаалт" гэсэн маягт байгаа боловч уг маягтаар томилолтоор ажилласан хугацаанд ногдох хоолны мөнгөний тооцоог гаргаж гарт олгох дүнг тодорхойлдог, жолоочийн замын хуудсанд тухайн сард зарцуулсан тос, тосолгооны материалын тоо хэмжээг тайлагнах нь зүйтэй байна. Мөн бэлэн мөнгөний орлого зарлагын баримтыг

батлагдсан маягт зааврын дагуу хөтөлдөггүй зарлагын баримтын 2 хувь, харилцах данснаас авсан бэлэн мөнгөний орлогын баримтын тасалбар кассын баримтад үдэгдсэн байна.

19. Анхан шатны баримт /шаардах хуудас/-гүй сэлбэг материал зардалд тооцсон, бараа материалын зарлагын тайлан шаардах хуудасны тоо хэмжээнээс зөрүүтэй байна. Тухайлбал Их хэт салбар 1-р сард 1,300,000.0 төгрөгийн үнэ бүхий камаз дугуй 2ш , 9-р сард 550,000.0 төгрөгийн үнэ бүхий сэлбэг 1ш , 7-р сард Б.Батдорж 85л дизель түлш шаардах хуудасгүй тус тус зардалд тооцсон, 7-р сард шаардах хуудсаар 50 кг цемент олгосон байхад нярвын тайлангаар 10кг -н зарлага гаргасан, Өргөн салбар 4-р сард 10 нэр төрлийн 172,39.91 төгрөгийн материал шаардах хуудасгүй зарлага гаргасан байна.
20. Шатахууны орлого зарлагын тайланг жолооч тус бүрээр гаргаж жолоочийн үлдэгдлийг баталгаажуулдаггүй, жолоочийн замын хуудсанд хяналт тавих үүрэг бүхий Ерөнхий инженер /түүний эзгүйд Үйлдвэрлэл техникийн хэлтсийн дарга/ гарын үсэг зураагүй дотоод хяналт хангалтгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Тус компани Айраг, Их хэт, Өргөн гэсэн 3 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд салбар болон төв компаний хоорондын тооцооны дансыг эргэлтийн хөрөнгө хэсэгт бусад эргэлийн хөрөнгө дансанд сөрөг утгаар илэрхийлж тайлагнасан, Өргөн салбар 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр байгуулагдсан гэх боловч салбарын санхүүгийн байдлын тайлан 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хуримтлагдсан ашгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь салбар болон төв компаний бүртгэл, хоорондын тооцоог хэрхэн бүртгэх талаар бодлогын баримт бичигт тусгаж эцэслэн батлаагүйтэй холбоотой байна.

Энэ нь иж бүрэн байдал, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

НББББичигт өөрчлөлт оруулах шаардлагатай байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

НБББББичигийг ойрын хугацаанд батлуулж мөрдөх, салбар дээрх хоорондын тооцооны дансыг өглөгийн дансаар, төв компани дээрх хоорондын тооцооны дансыг авлагын дансаар тасралтгүй байх зарчмаар бүртгэх нь зүйтэй мөн хоорондын тооцооны данстай холбоотой журам, анхан шатны маягтуудыг шинээр боловсруулах шаардлагатай байна.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Өмчийн өөрчлөлтийн тайланд эздийн өмчийн бусад хэсэг данс 12,535,035,088.33 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд энэ дансны бүртгэлийг тодорхой болгож компаний дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд зохих өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна

Энэ нь бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Компаний тухай хууль зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Бусад эзний өмчийн дансны бүртгэл буруу байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Компаний дүрэм улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох хуулийн дагуу өөрчлөлт оруулах, төсвийн хөрөнгөөр хүлээн авсан тохиолдолд өглөгийн дансаар бүртгэж /эздийн өмчийн дансаар биш/ дараа нь ИТХ-р өглөгийг шийдвэрлүүлж /өрийг хувьцаа гаргах замаар төлөх/ байх нь зүйтэй

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээрх үлдэгдэл тооцоо гаргасан нярвын тайлангийн үлдэгдэлтэй тохирохгүй байна. Тухайлбал нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэл 5-р сард бензин 19,478.44 /12л/ төгрөг, 6-р сард бензин 35,412.81 /22л/ төгрөг, дизель түлш 20,800.0 /11л/ төгрөг, 7-р сард бензин 78,216.08 /47л/ төгрөг, дизель түлш 4,788,290.56 /2350л/ төгрөг, 9-р сард дизель түлш 71,335.52 /35л/ төгрөг, 10-р сард бензин 68,123.83 /39л/ төгрөг, дизель түлш 159,142.9 /75л/ төгрөг, 11-р сард бензин 44,470.11 /24л/ төгрөг, 12-р сард бензин 35,548.62 /20л/ төгрөг, дизель түлш 476,036.36 /212л/ төгрөгөөр тус тус нярвын тайлангаас илүү байна

Энэ нь иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Няравын тайланг сар бүр хянаж үлдэгдлийг баталгаажуулаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Няравын бараа материалын тайлангийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 Удирдлагын дээд болон дотоод хяналт

3.4.1 Илрүүлэлт:

Тухайн компаний Өргөн салбарт нярав байхгүй нягтлан бодогч эд хөрөнгөө хариуцан тайлан гаргадаг байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Хөрөнгө эзэнгүйдэх, шамшигдах, эрх үүрэг давхардах.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ" гэж заасан бөгөөд нягтлан бодогч өөрөө эрх олгох эрх бүхий албан тушаалтан тул няравын ажлыг хавсруулан ажиллуулах нь буруу байна.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.5 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.5.1 Илрүүлэлт:

Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлын хөлсийг олгож ХХОАТ-ын тооцоо хийсэн боловч НДШ-ийн тооцоо хийгээгүй байна. Тухайлбал 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдөр П.Эрдэнэбатад 3,000,000.0 төгрөг, 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр В.Болорцэцэгт 600,000.0 төгрөг тус тус олгосон байна. Мөн Айраг салбарын ажилчдад орон сууцны халаалтын хөлсний хөнгөлөлтийг үзүүлж байгаа боловч хөнгөлөлтөөс НДШ-ийн тооцоо хийгээгүй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хууль зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

НДШ-ийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцоогүй байх, торгууль, алданги хүлээх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1.2 "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс", 1.4 "аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.6 Балансын данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

2018 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/31 тоот тушаалаар үл хөдлөх хөрөнгө /3 өрөө байр/ 17,000,000.0 төгрөгөөр худалдан авсан боловч эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ байгууллагын нэр дээр байгаа эсэх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 "Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.7 Удирдлагын дээд болон дотоод хяналт

3.7.1 Илрүүлэлт:

Компаний захирлын гаргасан тушаалын үндэслэл гаргасан шийдвэрт хамаарахгүй үндэслэл муутай тушаал гаргаж хөрөнгө зарцуулсан байна. Тухайлбал 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр А/116 тоот тушаалаар нэр бүхий 8 хүнд 9,000,000.0 төгрөгийн урамшуулал олгосон байна. Мөн гаргаж буй тушаалын утга найруулгын хувьд анхаарах зүйл байна. Тухайлбал 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Б/220 тоот тушаалын 2 дугаар заалтаар Т.Энхтуяаг борлуулалтын орлогоор цалинжуулж бусад нэмэгдлийг олгохоор заасан боловч цалинг "Орлогоор цалинждаг ажилчдын цалин тооцож олгох журам"-н дагуу бодож олгодог байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Компаний тухай хууль, компаний дүрэм тус тус зөрчсөн байна.

3.7.2 Эрсдэл:

Эрх зүйн үндэслэлгүй тушаал шийдвэр гаргаснаар зарцуулсан хөрөнгийг эргэн төлөх.

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Захирлын тушаалын үндэслэлийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд гаргах, тушаалыг ойлгомжтой, хоёрдмол утгагүй төлөвлөж батлах.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.8 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.8.1 Илрүүлэлт:

2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 2017-2019 онд мөрдөхөөр хамтын гэрээ байгуулан 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр бүртгүүлсэн бөгөөд тус гэрээ өнөөдрийг хүртэл мөрдөгдсөөр байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөхөөр байна. Өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 " хамтын гэрээг нэг жил түүнээс дээш хэлэлцээрийг хоёр жилийн хугацаагаар тус тус байгуулна" 15 дугаар зүйлийн 15.5 "бүртгүүлээгүй буюу хууль тогтоомжид нийцээгүй эсхүл ажилтны эрхийн байдлыг хууль тогтоомжид зааснаас дордуулсан хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг хүчин төгөлдөр бус гэж үзэх бөгөөд түүнийг биелүүлэхгүй" гэсэн заалтууд байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн байна.

3.8.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх

3.8.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын захиргаа, ҮЭ-н хооронд байгуулсан хамтын гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн батлуулж ажиллах.

3.8.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.9 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.9.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдэх хуудсыг батлагдсан маягт зааврын дагуу хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар зөрчсөн байна.

3.9.2 Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж зөрчигдөх.

3.9.3 Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан маягт зааврын дагуу мэдэгдэх хуудсыг хөтлөх.

3.9.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.10 Зардлын данстай холбоотой асуудал

3.10.1 Илрүүлэлт:

Тус компаний Айраг салбар бэлнээр мөнгө шаардлагатай болсон үед 1-р гарын үсгийг Ш.Шинэбилэг, 2-р гарын үсгийг М.Отгонтуяа нар зуран Санхүү-3 гэсэн тамга дарж нярав Б.Энхчимэгийн хувийн дансанд шилжүүлэн авч зарцуулдаг байна. Гэвч тухайн данснаас хэзээ хэдэн төгрөг авсан баримт байхгүй байна. Тухайлбал 2018 оны 12 дугаар сарын 17-нд 1,995,800 төгрөг бэлнээр авсан баримт байхгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.10.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй байх

3.10.3 Өгсөн зөвлөмж:

Харилцах данснаас бэлэн мөнгө гаргах тохиолдолд бэлэн мөнгөний зарлагын баримт /чек/-р зарлагын гүйлгээ хийх нь зүйтэй

3.10.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.11 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.11.1 Илрүүлэлт:

2018 оны 10 дугаар сарын сарын 15-ны өдрийн А/99 тоот тушаалаар баталсан байгууллагын дотоод журмын 12.3.5-д "Ажилтанд ар гэрийн гачигдал, сувилуулах, суралцах зэрэг бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар түр чөлөө хүссэн тохиолдолд цалинтай чөлөө олгож болно" гэж заасан байна. Энэ нь чөлөө олгох нөхцөл ойлгомжгүй мөн ямар цалин хөлс олгох нь тодорхойгүй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн байна.

3.11.2 Эрсдэл:

Батлагдсан журмуудыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх

3.11.3 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 "ажил олгогч нь ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгож болно", 80.2 "чөлөөтэй байгаа хугацаанд тэтгэмж олгох эсэх асуудлыг хамтын ба хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд зааснаар зохицуулна" гэсэн заалтуудыг үндэслэн чөлөө олгох шалтгаан, чөлөөтэй байх хугацаанд тэтгэмж олгох эсэх, олговол ямар тохиолдолд хэдий хэмжээний тэтгэмж олгохыг дотоод журам, хамтын гэрээнд тодорхой тусгах нь зүйтэй

3.11.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.12 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж

3.12.1 Илрүүлэлт:

Дансдын ерөнхий журнал Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 100 тоот тушаалаар баталсан маягтын дагуу гардаггүй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан заавар зөрчсөн байна.

3.12.2 Эрсдэл:

Сангийн сайдын батлагдсан тушаалын дагуу санхүүгийн програмд өөрчлөлт оруулаагүй

3.12.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмыг Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан зааварт нийцүүлэх, ерөнхий журналыг харьцсан дансаар гаргадаг болох нь зүйтэй

3.12.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.13 Зардлын данстай холбоотой асуудал

3.13.1 Илрүүлэлт:

Автомашин түрээслэн ажил гүйцэтгэж байгаа боловч гэрээнд гүйцэтгэх ажил үүргийн тоо хэмжээ, ажиллах норм, хугацааг тодорхой тусгаагүй, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэдэггүй байна. Тухайлбал Айраг салбар 2018 оны 12 дугаар сарын 14-нд XMGL маркын 47-79 дугаартай машин түрээслэн 1,980,000.0 төгрөг төлсөн байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль тус тус зөрчсөн байна.

3.13.2 Эрсдэл:

Гэрээний үүргийн биелэлтийг шалгаагүй байх.

3.13.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээнд гүйцэтгэх ажил үүрэг, ажлын тоо хэмжээ, норм норматив, ажиллах хугацааг тодорхой тусгаж үр дүнг тооцох нь зүйтэй

3.13.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.14 Балансын данстай холбоотой асуудал

3.14.1 Илрүүлэлт:

Байгууллагуудаас нэхэмжилсэн дулаан, цэвэр, бохир ус зарцуулалтын тооцооны нэхэмжлэл, борлуулалтын тайлан хоорондоо зөрүүтэй байна. Тухайлбал Дорноговь аймгийн Шүүхийн тамгын газарт бичсэн 1-11 сарын нэхэмжлэл борлуулалтын тайлантай 2965010 төгрөгийн зөрүүтэй, 12 дугаар сард айл өрхөөс авах 718020 төгрөгийн тооцоог Шүүхийн тамгын газрын үлдэгдлээс хаасан, УССТөвд бичсэн нэхэмжлэл 3575609 төгрөгөөр илүү, Зүүнбаян Хүүхдийн цэцэрлэгийн илүү төлсөн 454098 төгрөгийг орон сууцны авлагын дансанд хааж бичсэн байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.14.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх

3.14.3 Өгсөн зөвлөмж:

Борлуулалтын нэхэмжлэлийг борлуулалтын тайлантай тулган шалгасны үндсэн дээр харилцагч байгууллагуудад бичиж өгөх, орон сууцны авлага хааж байгаа тохиолдолд нэрсийн жагсаалтыг гаргаж харилцагч байгууллагатай тооцоо нийлж ажиллах.

3.14.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.15 Зардлын данстай холбоотой асуудал

3.15.1 Илрүүлэлт:

Дараа тайлангаар мөнгө гаргахдаа юунд зориулж, хаанаас юу худалдан авах тухай мөнгө хүссэн өргөдөлд тодорхой тусгадаггүй шаардлагатай хөрөнгийг тооцож өгдөггүй бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан илүү үлдэгдэлтэй гардаг байна. Тухайлбал 2018 оны 6 дугаар сарын 14-нд 310,424.0 төгрөг, 2018 оны 9 дүгээр сарын 25-нд 11,467,495.0 төгрөг шаардлагатай мөнгөнөөс илүү олгосон байна. Мөн мөнгөн урьдчилгааны тайлан /дараа тайлан/-г олгосон тухай бүр тайлагнадаггүй, хэд хэдэн урьдчилж авсан бэлэн мөнгөний тайланг нийлүүлэн тайлагнадаг байна. Тухайлбал 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гаалийн татварт зориулан Ц.Адьяасүрэнгийн авсан 20,000,000.0 төгрөгийг 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн тайлангаар хаасан байна.

Энэ нь толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.15.2 Эрсдэл:

Дараа тайлангаар авсан мөнгөний зарцуулалтын тооцоог хугацаандаа хийдэггүй байх.

3.15.3 Өгсөн зөвлөмж:

Дараа тайлангаар мөнгөн урьдчилгаа олгох, тайлагнах, шалгаж хүлээн авах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх журмыг баталж мөрдөх нь зүйтэй

3.15.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.16 Балансын данстай холбоотой асуудал

3.16.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй тоо хэмжээгээр тайлагнасан байна. Няравын шатахууны тайлан НББ-н үлдэгдэлтэй зөрүүтэй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар зөрчсөн байна.

3.16.2 Эрсдэл:

Бараа материалын тайлангийн үлдэгдлийг санхүүгийн тайлантай тулгах

3.16.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан зааврыг мөрдөж, бараа материалд тавих дотоод хяналтыг сайжруулах

3.16.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.17 Орлогын данстай холбоотой асуудал

3.17.1 Илрүүлэлт:

Тус компани үдсэн үйл ажиллагаанаас гадна туслах үйл ажиллагааны чиглэлээр компаний ид ачааллын бус цагаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр зарласан тендерт оролцон ажил гүйцэтгэсэн байна. Гэхдээ туслах үйл ажиллагааны чиглэлээр олсон орлого зардал, ашиг алдагдлын тооцоог гүйцэтгэсэн ажил тус бүрээр санхүүгийн тайланд тодруулаагүй байна. 2018 онд 1,975,035,163.0 төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.17.2 Эрсдэл:

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байх

3.17.3 Өгсөн зөвлөмж:

Компани ид ачааллын бус цагаар туслах үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тус үйл ажиллагаанаас ямар хэмжээний ашиг орлого байгаа

байдалд дүгнэлт өгөх олсон ашгийг юунд зарцуулах талаар ИТХ, ТУЗ-р шийдвэр гаргаж ажиллах нь зүйтэй байна.

3.17.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.18 Зардлын данстай холбоотой асуудал

3.18.1 Илрүүлэлт:

Компани өөрийн онцлогт тохируулан анхан шатны маягтууд хөтөлж байгаа боловч эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй зарим анхан шатны маягт ойлгомжгүй, тодорхой бус нягтлан бодох бүртгэлээр дамжуулан хүлээн авах мэдээллийн хэрэгцээг хангахгүй байна. Тухайлбал "томилолт олгох жагсаалт" гэсэн маягт байгаа боловч уг маягтаар томилолтоор ажилласан хугацаанд ногдох хоолны мөнгөний тооцоог гаргаж гарт олгох дүнг тодорхойлдог, жолоочийн замын хуудсанд тухайн сард зарцуулсан тос, тосолгооны материалын тоо хэмжээг тайлагнах нь зүйтэй байна. Мөн бэлэн мөнгөний орлого зарлагын баримтыг батлагдсан маягт зааврын дагуу хөтөлдөггүй зарлагын баримтын 2 хувь, харилцах данснаас авсан бэлэн мөнгөний орлогын баримтын тасалбар кассын баримтад үдэгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

3.18.2 Эрсдэл:

Анхан шатны баримтгүй байх, баримтын шаардлага хангахгүй байх

3.18.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно" гэсэн заалтыг үндэслэн холбогдох анхан шатны баримтыг шаардлагын хэмжээнд боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөх, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан зааврыг мөрдөх нь зүйтэй

3.18.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.19 Зардлын данстай холбоотой асуудал

3.19.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримт /шаардах хуудас/-гүй сэлбэг материал зардалд тооцсон, бараа материалын зарлагын тайлан шаардах хуудасны тоо хэмжээнээс зөрүүтэй байна. Тухайлбал Их хэт салбар 1-р сард 1,300,000.0 төгрөгийн үнэ бүхий камаз дугуй 2ш , 9-р сард 550,000.0 төгрөгийн үнэ бүхий сэлбэг 1ш , 7-р сард Б.Батдорж 85л дизель түлш шаардах хуудасгүй тус тус зардалд тооцсон, 7-р сард шаардах хуудсаар 50 кг цемент олгосон байхад няравын тайлангаар 10кг -н зарлага гаргасан, Өргөн салбар 4-р сард 10 нэр төрлийн 172,39.91 төгрөгийн материал шаардах хуудасгүй зарлага гаргасан байна.

Энэ нь иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.19.2 Эрсдэл:

Анхан шатны дэмжих баримтгүй ажил гүйлгээг бүртгэсэн байх.

3.19.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл заалтыг мөрдөж ажиллах

3.19.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.20 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.20.1 Илрүүлэлт:

Шатахууны орлого зарлагын тайланг жолооч тус бүрээр гаргаж жолоочийн үлдэгдлийг баталгаажуулдаггүй, жолоочийн замын хуудсанд хяналт тавих үүрэг бүхий Ерөнхий инженер /түүний эзгүйд Үйлдвэрлэл техникийн хэлтсийн дарга/ гарын үсэг зураагүй дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн байна.

3.20.2 Эрсдэл:

Холбогдох заавар, журмыг мөрдөөгүй байх

3.20.3 Өгсөн зөвлөмж:

Тайлан тасалбар болгож байгаа хугацаагаар жолооч нарын шатахууны үлдэгдлийг баталгаажуулж, хуульд заасан хугацаанд тооллого хийж үр дүнг тооцож ажиллах, шатах тослох материалын зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.20.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Агууллагын нэр : "ЧАНДМАНЬ ИЛЧ" ХХК

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	143,580,969.51	214,867,805.64
1.1.2	Дансны авлага	1,097,082,992.70	2,437,311,556.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	157,291.00
1.1.4	Бусад авлага	45,935,155.28	1,431,243.33
1.1.6	Бараа материал	548,228,072.93	512,248,355.42
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	515,900.00	4,617,450.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,835,343,090.42	3,170,633,701.39
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,480,159,004.83	16,258,762,012.13
1.2.2	Биет бус хөрөнгө	24,102,732.56	2,481,936,324.71
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,504,261,737.39	18,740,698,336.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,339,604,827.81	21,911,332,038.23
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	659,234,951.56	719,960,048.57
2.1.1.3	Татварын өр	226,296,785.41	398,044,120.68
2.1.1.4	НДШ - ийн өглөг	168,038,212.06	90,639,102.09
2.1.1.5	Богино хугацаат зээл	114,400,000.00	1,081,899,452.05
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	69,876,955.34	28,537,632.93
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,237,846,904.37	2,319,080,356.32
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,841,366,587.73	1,841,366,587.73
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,841,366,587.73	1,841,366,587.73
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,079,213,492.10	4,160,446,944.05
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	2,924,821,597.13	2,924,821,597.13
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,642,921,053.10	8,121,022,173.06
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	11,249,989,242.38	12,535,035,088.33
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(5,557,340,556.90)	(5,829,993,764.34)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /		(255,511,798.98)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	(5,557,340,556.90)	(5,557,340,556.90)
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,260,391,335.71	17,750,885,094.18
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,339,604,827.81	21,911,332,038.23

4417144353
ЕЮА0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр : "ЧАНДМАНЬ ИЛЧ" ХХК

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1 Борлуулалтын орлого (цэвэр)	6,158,715,035.96	7,791,078,016.15
2 Борлуулалтын өртөг	5,898,600,102.74	7,168,992,397.66
3 Нийт ашиг(алдагдал)	260,114,933.22	622,085,618.49
4 Түрээсийн орлого		
5 Хүүний орлого	39,027,364.12	19,318,113.39
6 Ногдол ашгийн орлого		
7 Эрхийн шимтгэлийн орлого		
8 Бусад орлого		
9 Борлуулалт, маркетингийн зардал	-	140,727,315.75
10 Ерөнхий ба удирдлагын зардал	499,744,350.81	507,784,484.23
11 Санхүүгийн зардал		
12 Бусад зардал	73,906,451.61	69,864,353.41
13 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	475,119.16	(2,240,840.86)
14 Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(166,904,753.32)
15 Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16 Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17 Бусад ашиг (алдагдал)	13,777,869.84	(9,063,006.14)
18 Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(260,255,516.08)	(255,181,021.83)
19 Орлогын татварын зардал	613,783.48	330,777.15
20 Татварын дараах ашиг (алдагдал)	(260,869,299.56)	(255,511,798.98)
21 Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(260,869,299.56)	(255,511,798.98)
23 Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
24 Орлогын нийт дүн	(260,869,299.56)	(255,511,798.98)
25 Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4417144353
EHOA0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр : "ЧАНДМАНЬ ИЛЧ" ХХК

/ төгрөгөөр /

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	2018 оны 12-р сарын 31
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,924,821,597.13	4,642,921,053.10	10,625,211,864.38	(5,283,673,482.37)	12,909,281,032.24
2	Өмчид гарсан өөрчлөлт				(12,797,774.97)	(12,797,774.97)
3	Залруулсан үлдэгдэл	2,924,821,597.13	4,642,921,053.10	10,625,211,864.38	(5,296,471,257.34)	12,896,483,257.27
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(260,869,299.56)	(260,869,299.56)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			624,777,378.00		624,777,378.00
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн					-
9	2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,924,821,597.13	4,642,921,053.10	11,249,989,242.38	(5,557,340,556.90)	13,260,391,335.71
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны				(17,141,408.46)	(17,141,408.46)
11	Залруулсан үлдэгдэл	2,924,821,597.13	4,642,921,053.10	11,249,989,242.38	(5,574,481,965.36)	13,243,249,927.25
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(255,511,798.98)	(255,511,798.98)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-		1,285,045,845.95	-	1,285,045,845.95
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн		3,478,101,119.96			3,478,101,119.96
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,924,821,597.13	8,121,022,173.06	12,535,035,088.33	(5,829,993,764.34)	17,750,885,094.18

4417144353
EIOA0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр : "ЧАНДМАНЬ ИЛЧ" ХХК

ҮЗҮҮЛЭЛТ		/ төгрөгөөр /	
		2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,845,389,591.82	7,575,155,584.87
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,243,851,715.02	6,986,543,336.28
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		136,259.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	366,000.00	502,406.00
	Буцаан авсан албан татвар		142,477.00
	Татаас, санхүүжилтийн орлого	371,850,000.00	525,964,300.00
	Бусад мөнгөн орлого	229,321,876.80	61,866,806.59
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,453,477,146.48	7,881,515,862.56
	Ажиллагчдад төлсөн	1,591,929,498.55	1,678,319,604.23
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	469,126,458.01	469,724,452.77
	Бараа материал худалданавахад төлсөн	1,997,410,411.10	3,099,877,281.32
	Ашиглалтын зардалд төлсөн	953,434,020.45	1,001,453,204.55
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	347,199,971.54	476,013,005.60
	Хүүний төлбөрт төлсөн		1,000.00
	Татварын байгууллагад төлсөн	479,010,593.93	496,174,666.93
	Даатгалын төлбөрт төлсөн	366,000.00	16,273,658.89
	Бусад мөнгөн зарлага	615,000,192.90	643,678,988.27
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	391,912,445.34	(306,360,277.69)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	154,038,300.00	501,645,166.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	127,638,300.00	466,478,186.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	26,400,000.00	35,166,980.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(154,038,300.00)	(501,645,166.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	200,000,000.00	1,141,300,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	200,000,000.00	1,141,300,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	402,154,515.34	262,007,720.18
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	402,154,515.34	262,007,720.18
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(202,154,515.34)	879,292,279.82
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	35,719,630.00	71,286,836.13
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	107,861,339.51	143,580,969.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	143,580,969.51	214,867,805.64

4417144353
ЕНОА0056 9025707